



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 10/93

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэвэрлэгээ, үйлчилгээний материал /бүх алба, салбар/ нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Ц.Болдсүрэн	(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Аж ахуйн үйлчилгээ, дулаан санхтехникийн албаны Аж ахуй, барилга засварын хэсгийн дарга)
Гишүүд:	Б.Тамир	(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Аж ахуйн үйлчилгээ, дулаан санхтехникийн албаны Аж ахуй, барилга засварын хэсгийн мэргэжилтэн)
	П.Лхагважав	“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн (тохиролцсоноор)
	Д.Аззаяа	“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн (тохиролцсоноор)
Нарийн бичгийн дарга:	Э.Энхжин	(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Ц.Болдсүрэн)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Энхжин)-д даалгасугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН